# School - to - School Exchange on DRR

**Гамшгийн эрсдэлийг бууруулахын төлөөх (DRR) сургууль хоорондын хамтын ажиллагаа**




Гамшгийн аюулгүйн сургалтаас сурсны дагуу, гамшгийн эрсдэлийг бууруулах ажлыг сайтар хэрэгжүүлж чадвал хүний амь насыг аврах боломжтой болохыг илэрхийлсэн зураг

# Program Introduction

Энэхүү төсөл нь гамшиг тохиолдохоос өмнө урьдчилан сэргийлэх аргад суралцахад чиглэгдсэн юм. Мөн сурч мэдсэнээ бусадтай хуваалцах, сурагчдын суралцсаныг гадагшаа түгээснээр олон янзын бүс нутгийн гамшгийн эрсдэлт хүчин зүйлсийг олж мэдэхэд чиглэгдлээ.

## 1 why

Байгалийн үзэгдэл, хүнээс үүдэлтэй янз бүрийн аюулд урьдчилан бэлдэхгүй бол бидний амь нас, эд хөрөнгө, байгаль орчинд их их хохирол учирч болзошгүй. Эдгээр хүндрэлээс урьдчилан сэргийлэх, аливаа аюул тохиолдоход эдгээр аюулд эрдэнэт хүний амь нас төдийгүй өөрийн амь насыг ч аврах чадварыг хөгжүүлэх шаардлагатай юм.

## 2 what

- Гамшиг гэж юу болохыг тодорхой ойлгож мэдэх.
- Өөрийн (бидний) эргэн тойрон дахь эрсдэлийн хүчин зүйлсийг таниж мэдэх.
- Гамшгаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх ёстойг сурч мэдэх.

## 3 how

- Суралцах, хэрэгжүүлэх, бусадтай хуваалцах гэсэн үе шатуудаар дамжуулан мэдлэгийг өөрийн болгох.
- Олон янзын бүс нутаг (орчин байдал)ийн сурагчидтай мэдлэгээ хуваалцах замаар сургалтын цар хүрээг тэлэх.
- Сургалтын үйл явц нь сурагчдын сайн дурын оролцоо, дадлага ажил бүхий агуулгаас бүрдэнэ.

## 4 content

- Гамшгийн эрсдэлийг бууруулах (эрсдлийн хүчин зүйл, эмзэг байдал, гамшиг, тэсвэрлэх чадвар) тухай ойлголт, нэр томьёог сурах
- Гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага хийх
- Гамшгаас урьдчилан сэргийлэх дадлагаас хуваалцах

---

DRR Гамшгийн эрсдэлийг бууруулах гэсэн утгатай.

**Program road map**

## STEP1

### Гамшгийн талаар судлах

①Гамшгийн эрсдэлийг бууруулах гэж юу болохыг ойлгох

②Гамшгийн аюулгүй байдлын сургалтын ач холбогдлыг мэдэх

③Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар суралцах

-> Эрсдэлийн арал тоглоом

④ Сурч мэдсэнээ давтах

-> Бинго тоглоом

## STEP2

Гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага хийх

①Гамшгийн талаарх туршлагаа хуваалцах (гэр бүлийн хүрээнд)

②Өөрийн орон нутгийн эрсдэлт хүчин зүйлсийн газрын зургийг хийх (эмзэг байдлыг судлах)

③Орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, нөлөөллийг бууруулах гарын авлага хийх

④Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг бий болгох

⑤ Сэтгэгдлээ хуваалцах

## STEP3

Гамшгаас урьдчилан сэргийлэх дадлагаас хуваалцах

① Мэндчилгээ - Сургуулийн танилцуулга - Өөрийн орон нутгийн орчны байдлыг танилцуулах

②Гамшгийн эрсдэлийг бууруулах дадлагын үр дүнг танилцуулах (Өөрийн бүс нутагт эрсдэлт хүчин зүйлс, эрсдэлт хүчин зүйлүүд бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тайлагнах – 3баг)

③ Асуулт, хариултын цаг

④ Дүгнэлт

배우고 | 실천하고 | 나누는

| Сургалтын сэдэв | Гамшгийн эрсдэлийг бууруулах тухай ойлголт | Хугацаа | 40мин |
|---|---|---|---|
| Гол ойлголтууд | Гамшиг, эрсдэлийн хүчин зүйлс, эмзэг байдал, уян хатан байдал | Бэлтгэх зүйл | ppt |
| Сургалтын зорилго | Гамшиг, эрсдэлт хүчин зүйл хоёрыг ялгаж сурах.<br>Төрөл бүрийн эрсдэлт хүчин зүйлийн эмзэг байдлыг (сул тал) ойлгож авах.<br>Урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зэргээр дамжуулан гамшгийн хохирлыг бууруулах боломжтой гэдгийг ойлгох. | | |

★★ Үндсэн агуулга

Хар салхи, газар хөдлөлт, үер гэх мэт эрсдэлт хүчин зүйлүүд нь байгалийн үзэгдэл төдий мэт харагдавч хэрхэн урьдчилан сэргийлж, бэлтгэлтэй байж, эрсдэлийг бууруулж чадахаас хамааран гамшгийн хэмжээнд хүрж ч болно, зүгээр байгалийн үзэгдэл болон өнгөрч ч болдгийг чухалчилна.

【 Гамшгийн эрсдэлийг бууруулах тухай ойлголт 】

◊ Эрсдэлт хүчин зүйлс



✓Ойлголт

Хэдийгээр байгалийн үзэгдэл ч гэсэн хүмүүсийн хувьд урьдчилсан бэлэн байдлыг хангаагүйн улмаас амь нас, эд хөрөнгө, байгаль орчинд аюул авчирч болохыг хэлнэ

✓ Эрсдэлт хүчин зүйлсийн ангилал

- Байгалийн хүчин зүйлс: газар хөдлөлт, хар салхи, галт уулын дэлбэрэлт, үер гэх мэт
- Хүнээс үүсэлтэй хүчин зүйлс: байгаль орчны бохирдол, үйлдвэрийн осол гэх мэт

◊ Эмзэг байдал



✓Ойлголт

Эрсдэлийн хүчин зүйлсийн улмаас хохиролд амархан өртөхийг хэлнэ

✓ Эмзэг байдал бий болдог шалтгаан

-Цаг агаарын өөрчлөлт, ядуурал, боловсролын тэгш биш байдал, гамшгийн даатгалд хамрагдаагүй байдал, тухайн газар нутгийн хэл болон орчны мэдээллийн дутмаг байдал

◊ Гамшиг



✓Ойлголт

Эрсдэлийн хүчин зүйлсийн улмаас амь нас, эд хөрөнгө, байгаль орчин, амьжиргаанд нь хохирол учрахыг хэлнэ

◊ Нөхөн сэргээгдэх чадвар

✓Эрсдэлийн хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх эсвэл аюулаас болж гамшиг нүүрлэх үед урьдчилан бэлтгэлтэй байснаар гамшгийн дараа буцаад хэвийн байдалдаа орох чадвар







| Гамшгийн хохирлоос хэрхэн бүрэн гарах вэ | Эрсдлийн хүчин зүйлсээс үүдэлтэй хор хөнөөлөөс хэрхэн үр дүнтэй зайлсхийх вэ | Эрсдлийн хүчин зүйлсийн хохирлыг хэрхэн бууруулах вэ |
|---|---|---|

※ Аюулын эрсдэлтэй бүсэд амьдарч байгаа хүмүүс ойр орчин тойронд ямар эрсдэлийн хүчин зүйлс байгааг мэдэж байх хэрэгтэй. Зурган дээрээс харвал хүмүүс хад чулууг анхаарч харахгүй байгаагаас эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. (Хүмүүс хад руу анхаарч харж байна гэдэг нь эргэн тойрны эрсдэлийн хүчин зүйлсийг урьдчилан мэдэж, цаг хугацааны хувьд бэлтгэл хийх боломжтой гэсэн үг.)

※ Амь нас, эд хөрөнгө, байгаль орчин, амьжиргаанд нь хохирол учраагүй бол гамшиг гэж үзэхгүй. ( Тэгэхээр бидний хэрэглэж заншсан "байгалийн гамшиг" гэсэн нэршил нь оновчтой биш харин "байгалийн эрсдэлийн хүчин зүйлс" гэж хэлэх нь илүү оновчтой юм.
)

배우고 | 실천하고 | 나누는

| | | | |
|---|---|---|---|
| Сургалтын сэдэв | Урьдчилан сэргийлэх аргаас суралцах | Хугацаа | 40분 |
| Гол ойлголтууд | Tilly Smith, гамшгаас урьдчилан сэргийлэх | Бэлтгэх зүйлс | Tilly Smith бичлэг, тоглоомын хэрэгсэл |
| Сургалтын зорилго | Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтын ач холбогдлыг ойлгох.<br>Гамшгаас хэрхэн урьдчилан сэргийлэх, хохирлыг хэрхэн бууруулах аргын талаар ярьж чаддаг болох. | | |

★★ Үндсэн агуулга

Гамшгаас сэргийлэх аюулгүй байдлын сургалтын чухлыг бодит жишээн дээр тулгуурлан сурагчдад ойлгуулж, сурагчид энэхүү сургалтанд хамрагдсанаар гамшгийн үед эргэн тойрны хүмүүст тусламж үзүүлэгч нь болж чадахыг онцолж ойлгуулах.

【Тилли бичлэг үзэх】




Тилли Смис нь бүхий л зүйлд сониуч, сэргэлэн 10 настай энгийн нэгэн англи охин юм. 2004 оны 12 сарын 26-нд Номхон далайг бүхэлд нь нөмөрсөн цунамигаас болж Тайланд, Индонези зэрэг Азийн орнуудад 270,000 хүн амиа алдсан билээ.
Цунами болох үед Тилли охин гэр бүлийхэнтэйгээ хамт Тайландын Пүкет хотод амарч байжээ. Пүкет хотын ихэнх газрууд цунамигаас их хэмжээний хохирол амссан ч Тиллигийн байсан далайн эрэг дээр Тилли яаралтай арга хэмжээ авсны ачаар 100 гаруй хүний амийг аварч чаджээ. Ийм гэнэтийн аюул тулгарахад гэр бол болон эргэн тойрны хүмүүсийн амийг аварч чадсан нь 2 долоо хоногийн өмнө сургууль дээрээ газарзүйн хичээлийн цагаар цунами ирж буй дохио болон авах арга хэмжээний чухлыг багш нь зааж өгсөн байсны ач билээ.

【Эрсдэлийн арал тоглоом】



✓Тоглоомын танилцуулга

Хөлөгт тоглоомоор дамжуулан олон янзын эрсдэлийн хүчин зүйлсээс хэрхэн урьдчилан сэргийлэх, яаралтай арга хэмжээ авах, ямар үйлдлүүд нь гамшгаас үүсэх хохирлыг бууруулж болох мөн эмзэг байдалд хүргэх хүчин зүйлүүд болох талаар ойлголт өгнө

【 Hazar bingo тоглоом】




✓ Тоглоомын танилцуулга

Хичээлийн цаг дээр сурсан гамшгийн хохирлыг бууруулахтай холбоотой ойлголтуудыг сурагч сэргээн санаж, бататгах дасгал болох боломжтой тоглоом.
(сурсан мэдлэгээ ашиглан сурагчдаар өөрсдөөр нь бинго картыг бөглүүлнэ.)

【Дүгнэлт】

◊ step 1 Үнэлгээний хуудсыг бөглөх

※Тилли бичлэг
https://youtu.be/j95EyYln3Z8

※Болж өгвөл багш тоглоомонд аль болох оролцохгүй байх, багш эхлээд картан дээр байгаа агуулгыг урьдчилан уншиж мэдсэн байх, зааварчилгаа, асуулт, гэнэтийн картан дээрх агуулгыг сурагчид чанга дуугаар уншиж байгаа нь агуулгыг бусад сурагчдад сонсгож хуваалцахад маш чухал үүрэгтэй юм.

※ UNDRR, UNICEF хамтран 2002 онд зохиосон гамшгаас урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын сургалтанд зориулсан энэхүү тоглоом нь 20 гаруй орны хэл дээр орчуулагдан хэвлэгдэж, олон орны сургуулиуд сургалтандаа ашиглаж байна.

※Hazar bingo тоглоомыг хичээлийн төгсгөл хэсэгт тоглуулахад маш үр дүнтэй.

※ Сурагчдаас хэрэв ойролцоо утгатай үг гарч ирвэл хүлээн зөвшөөрөх эсэхийг хүүхдүүдэд хэлж өгөөрэй.
( аюул≠эрсдэлийн хүчин зүйл, хар салхи=хорикэйн=халуун орны салхи, эрсдэлийн хүчин зүйл=эрсдэлийн элемент)

| Step1 Үнэлгээний хуудас | | | |
|---|---|---|---|
| 배우고 실천하고 나누며 재난에서 살아남기 | Үйл ажиллагааны сэтгэгдэл, үнэлгээ | Огноо | |
| | | Нэр | |

【Хичээлээ эргэн дүгнэх】

| Өмнө нь мэдэж байсан зүйлс | Шинээр мэдэж авсан зүйлс | Илүү мэдэхийг хүсэж буй зүйлс |
|---|---|---|
| | | |

【Сургалтын талаарх сэтгэгдэл】 Өнөөдрийн сургалтын талаарх сэтгэгдлээ чөлөөтэй илэрхийлж бичнэ үү.

______________________________

______________________________

______________________________

【Сургалтын агуулга】

| Д.д | Агуулга | Үр дүн |
|---|---|---|
| 1 | Гамшиг, эрсдэлт хүчин зүйл хоёрын ялгаж чадна. | ☆☆☆☆☆ |
| 2 | Төрөл бүрийн эрсдэлт хүчин зүйлсээс эмзэг байдал үүсдэг шалтгааныг мэднэ | ☆☆☆☆☆ |
| 3 | Олон янзын нөхцөл байдал бүрд хэрэглэх урьдчилан сэргийлэх аргуудаас мэднэ | ☆☆☆☆☆ |

【Сургалтын арга】

| Д.д | Агуулга | Үр дүн |
|---|---|---|
| 1 | Багшийн тайлбар ойлгомжтой байлаа. | ☆☆☆☆☆ |
| 2 | Тоглоомоор дамжуулан эрсдэлийг бууруулах талаар илүү сайн ойлгож авлаа. | ☆☆☆☆☆ |

【Сургалтын хэрэглэгдэхүүн】

| Д.д | Агуулга | Үр дүн |
|---|---|---|
| 1 | PPT болон Тилли Смитийн видео бичлэгт ашигласан материалууд нь хичээлийн агуулгыг ойлгоход тохиромжтой байлаа. | ☆☆☆☆☆ |
| 2 | Тоглоомын хэрэгслүүд нь гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх аргуудыг ойлгоход тусалсан. | ☆☆☆☆☆ |

| Дасгал ажлын хуудас | | | |
|---|---|---|---|
| 배우고 실천하고 나누며 재난에서 살아남기 | Өөрийн орон нутгийн эрсдэлийн хүчин зүйлс болон эмзэг байдлын талаар судлах (гэр бүлд тулгуурлах) | Огноо | |
| | | Нэр | |

**【Гэр бүлийнхнийхээ хамт хийх】**

① Гэр бүлийнхэндээ гамшигтай холбоотой нэр томьёог тайлбарлах

- Эрсдэлийн хүчин зүйлс: газар хөдлөлт, хар салхи, галт уулын дэлбэрэлт, үер, байгаль орчны бохирдол, үйлдвэрийн осол гэх мэт нь урьдчилан бэлтгэл хийхгүй бол хүний амь, эд баялаг, орчинд хохирол учруулж болзошгүй.
- Эмзэг байдал : Эрсдэлийн хүчин зүйлээс хор хөнөөл учрах магадлал өндөртэй нөхцөл байдал
- Гамшиг : Эрсдэлийн хүчин зүйлийн улмаас амь нас, эд хөрөнгө, байгаль орчин, амьжиргааны хэрэгсэлд хохирол учирсан тохиолдол

② Гэр бүлийнхнийхээ гамшгийн туршлагаас хуваалцаарай

**【Багийн гишүүдийнхээ хамт хийх】** ※Бага ангийнхны хувьд орон нутгийг манай сургууль гэж авах нь илүү үр дүнтэй.

| Манай орон нутгийн эрсдэлийн хүчин зүйлс | Байрлал | Яагаад аюултай гэж бодож байгаа вэ? |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |

**【Эрчимтэй хайлт】**

※ Дээр дурдсан эрсдэлт хүчин зүйлсийн аль нэгийг нь сонгоод хэн, ямар шалтгаанаар тухайн эрсдэлд өртөх магадлал өндөр байгааг нягтлан харцгаая

Эрсдэлт хүчин зүйлс →

| | |
|---|---|
| Эмзэг байдалд байгаа хүмүүс | |
| Шалтгаан | |

| | | | |
|---|---|---|---|
| Сургалтын сэдэв | Манай орон нутгийн эрсдэлийн хүчин зүйлс болон эмзэг байдлыг таньж мэдэх | Хугацаа | 60мин |
| Гол ойлголтууд | Манай орон нутаг, эрсдэлийн хүчин зүйлс, эмзэг байдал | Бэлтгэх зүйл | Таблет, спикер, ватуум цаас, орон нутгийн газрын зураг |
| Сургалтын зорилго | Манай орон нутагт байгаа эрсдэлийн хүчин зүйлсийг олж илрүүлж чадах<br>Эрсдэлийн хүчин зүйлсээс эмзэг байдлыг дүгнэж чадах | | |

★★Үндсэн агуулга

① Гэр бүлийн гишүүдтэйгээ гамшгийн талаар ярилцах нь гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтын сурталчилгаа болох тэдийгүй энэ цаг дээр судлах агуулгын сэдэл болж болно.

② Гамшгаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн төлөвлөгөөг сургуулийн эргэн тойронд төвлөрсөн, сурагчдын туршлага хуримтлуулж болох бүсээр хязгаарлаж, хэрэгжүүлэх нь бодитой юм.

【Гэр бүлийнхнийхээ гамшгийн туршлагыг хуваалцах】

◊Гэр бүлийн гишүүдийнхээ туулсан гамшгийн тухай ярилцах
- Гэр бүлийнхэнд нь тохиолдсон гамшгийн нөхцөл байдал?
- Эрсдэлийн ямар хүчин зүйлээс үүсэж бий болсон гамшиг байсан бэ?
- Урьдчилан сэргийлэх боломжгүй байсан юм бол уу?

【Өөрийн орон нутгийн гамшгийн эрсдэлт хүчин зүйлсийн газрын зургийг гаргах】

◊Өөрийн орон нутгийн онцлогийг судлах
- Хиймэл дагуулаар авсан зураг (агаарын зураг)аар өөрийн орон нутгийг судлан харах (сургуулийн эргэн тойрныг)
- Манай орон нутаг (сургуулийн эргэн тойрон)ийн дүр төрх ямар байна вэ?

◊Өөрийн орон нутгийн эрсдэлт хүчин зүйлсийн газрын зураг хийх (дасгал ажил 1-ийг ашиглах)

①Өөрийн орон нутгийн эрсдэлт хүчин зүйлсийн карт хийх


Уулнаас том чулуу нурж ирэх боломжтой

✓ Хийх арга

Эрсдэлийн хүчин зүйлийг зүүн талд байгаа жишээний дагуу зургаар илэрхийлсний дараа товч тайлбар бичих (зургаар илэрхийлэх боломжгүй тохиолдолд үгээр илэрхийлж болохыг тайлбарлана.)

※Газрын зураг хийхэд 4т хэмжээтэй энгийн цаас, карт хийхэд 10cm*7cm хэмжээтэй цаас бэлтгэнэ. (label цаас хэрэглэх нь тохиромжтой)

② Орон нутгийн эрсдэлийн хүчин зүйлсийн газрын зураг дээр картаа наана.

Ийм арга бас бий

◊Манай орон нутгийн эрсдэлийн хүчин зүйлсийг багш болон сурагчид хамтдаа судалж
- Хайж олсны дараа сургууль дээрээ ирж картаа хийснээр эрсдэлийн газрын зургийг хийх боломжтой.

【Эрсдэлийн хүчин зүйлсийн эмзэг байдлын талаар олж мэдэх】

◊ Эрсдэлийн газрын зургаа ашиглан эмзэг байдлыг судлаарай
- Эрсдэлийн хүчин зүйлд хэн илүү өртөх вэ?
- Өртөх болсон шалтгаан нь юу вэ?

◊ Эрсдэлийн хүчин зүйл бүрээр эмзэг байдлыг газрын зураг дээр тэмдэглэх
-Эрсдэлийн хүчин зүйлээс хэн, яагаад хохирох магадлал өндөр байгааг Post-it цаасан дээр бичээд эрсдэлийн газрын зурагт наана.

※ Энэ хичээлд орохын өмнө <Дасгал ажлын хуудас 1>-ийг урьдчилсан даалгавар болгон өгсөн байна.

※ Google Maps-ийг ашиглах
※ Манай орон нутгийн байгаль орчин ямар байна, барилга олон байна уу, замын хөдөлгөөн ээдрээтэй байна уу, зам ээдрээтэй байна уу гэдгийг ярилцаж болно.
※ Манай нутаг дэвсгэрийн том газрын зургийг бэлдээрэй (хэрэв газрын зураг бэлдээгүй бол том зургийн цаасан дээр зөвхөн сургуулийн байршил, чиглэлийг тэмдэглээд тараана)
※ Эрсдэлийн хүчин зүйлийн зураглал гаргахад анги бүхэлдээ оролцох эсвэл багаараа хийх боломжтой.
※ Бага ангийн хувьд нутаг дэвсгэрийн эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэхэд хүндрэлтэй байгаа бол сургуулийнхаа эрсдэлт хүчин зүйлсийг олж, сургуулийнхаа эрсдэлт хүчин зүйлсийн зураглалыг хийж болно.

※Өөрсдийн нутаг дэвсгэрийг судлангаа эрсдэлийн газрын зургийг хийхийн тулд урьдчилсан аюулгүйн сургалт шаардлагатай бөгөөд багш очих газруудаар урьдчилан очиж танилцах нь зүйтэй

※ Хүүхдүүдийн олсон эрсдэлийн хүчин зүйлсийг нэг нэг бүрчлэн анхааран сонсож, тэдгээр эрсдэлт хүчин зүйлд өртөмтгий хүн эсвэл нөхцөл байдлын талаар тэдэнтэй ярилцах.

| | | | |
|---|---|---|---|
| Сургалтын сэдэв | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах | Хугацаа | 60мин |
| Гол ойлголтууд | Урьдчилан сэргийлэх, бэлэн байх, багасгах | Бэлтгэх зүйл | Өнгийн харандаа, ватуум цаас |
| Сургалтын зорилго | Өөрийн орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах гарын авлагыг хийж чадна.<br>Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, түүнийгээ өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх боломжтой. | | |

★★Үндсэн агуулга

Гамшиг тохиолдохоос өмнө бидний хийж чадах зүйлсийг нарийвчлан бодож үзээд, өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэн, үр дүнг тэмдэглэн, эргэцүүлэн бодох үйл явцыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Гамшигт тэсвэртэй байдлыг судлах】

◊<Step1>-ээс гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, үр дагаврыг бууруулах талаар сурсан ойлголтуудыг нэгтгэн дүгнэх




| | | |
|---|---|---|
| Гамшгийн хохирлоос бүрэн ангид байх | Эрсдэлийн хүчин зүйлээс үүдэлтэй хохиролд үр дүнтэй бэлтгэх чадвартай байх | Эрсдэлийн хүчин зүйлсийн хохирлыг багасгах |

【Өөрийн орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах гарын авлага хийх】

◊ Бидний өмнө нь хийсэн орон нутгийн аюулгүй байдлын газрын зургийг үзэж, орон нутагтаа аюул, эмзэг байдлаас хэрхэн урьдчилан сэргийлэх (урьдчилан сэргийлэх, бууруулах) талаар бодож үзээрэй.

- Эрсдэл, эмзэг байдлыг бууруулахын тулд юу хийж болох вэ?

◊ Өөрийн орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах гарын авлага хийх

- Найзуудтайгаа эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэх арга замуудын талаар ярилцаж, түүгээрээ товхимол (гарын авлага) хийх




| | | |
|---|---|---|
| Хавтас | Манай орон нутгийн орчин | Урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, нөлөөллийг бууруулах аргуудыг зураг болон бичгээр илэрхийлэх |

**Ийм арга бас бий**

✓Манай орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах гарын авлагын видео (UCC) хийх.

- Эрсдэлийн хүчин зүйлсийг зураг эсвэл видео хэлбэрээр авч, дараа нь видео бичлэгийн программыг ашиглан засварлаж видео болгох.

✓Манай орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах гарын авлагын ppt хийх

□※ Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, гамшгийг бууруулах үйл ажиллагааг нарийн ялгахаас илүүтэйгээр гамшгийн эрсдэлийг бууруулах арга замыг хайж олоход гол анхаарлаа хандуулах

※ Гамшгийн эрсдэлийг бууруулах гарын авлагын бүтцийг тухайн ангийн нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөрөөр тохируулж болно. Сурагчид гамшгийн эрсдэлийг хэрхэн бууруулах талаар санал бодлоо зураг болон бичгээр илэрхийлнэ.

※ Гамшгийн эрсдэлийг бууруулах гарын авлагыг UCC, ppt гэх мэт янз бүрийн аргаар зохион байгуулж болно.

【Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах】

◊ Гамшгийн эрсдэлийг бууруулах гарын авлагад дурдсан эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх (бэлтгэх, бууруулах) талаар бид юу хийж чадах талаар бодож, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах.

《Жишээ》

✓Эрсдэлт хүчин зүйлс

- Хуучин орон сууц (орон сууц нь хуучирсан байх, хуучирсан болон богино холболтын улмаас гал гарах нь элбэг)

✓Эмзэг байдал

- Галын хоргүй айлууд олон, галын аюулыг ноцтойгоор боддоггүй

| Дасгал ажлын хуудас | | | |
|---|---|---|---|
| 배우고 실천하고 나누며<br>재난에서 살아남기 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах | Огноо | 2002,5,1-5,14 |
| | | Нэр | Хон Гыл Дон |

| | |
|---|---|
| Миний хэрэгжүүлэх зүйлс | 1. Манай гэрт галын хор байгааг шалгах, хугацааг шалгах<br>2. Манай орон сууцанд галын аюулаас хамгаалах төхөөрөмж байрлуулсан байгаа эсэхийг шалгах<br>3. Судалгаа (галын хор байрлуулсан болон хугацаа нь дуусан эсэхийг шалгах)-ны асуулга зохиож, оршин суугчдаар бөглүүлэх |
| Хэзээ | 5 сарын 9-14 |
| Хэнтэй хамт | ..............................., .................................. (нэг орон сууцанд амьдардаг найз) |
| Арга | 1. Найз нартайгаа төлөвлөгөө зохиох (хамтдаа хийх ажлын огноо болон бэлтгэх зүйлс)<br>2. Судалгаа (галын хор байрлуулсан болон хугацаа нь дуусан эсэхийг шалгах) зохиох<br>3. Үр дүнгээ нэгтгэх |
| Үр дүн | Манай орон сууцанд галын хор байршуулаагүй давхрууд байсан учраас холбогдох хүмүүст очиж галын хор байршуулах шаардлагатай болохыг дуулгалаа.<br>Манай гэрт галын хор байсан ч хугацаа нь дууссан байсан учир энэ долоо хоногт шинээр худалдаж авлаа.<br>..................ний гэрт галын хор байгаагүй, .............................. гэрт галын хор байсан ч хугацаа нь дууссан байсан тул бүгдээрээ ахуйн зориулалттай галын хор шинээр худалдаж авлаа.<br>Манай орон сууцны бүх айл бүрээр галын хор байгаа эсэх, хугацаа нь хэтэрсэн эсэхийг тодруулсан асуулга бөглүүллээ.<br>Бидний байдлыг анхааран СӨХ-өөс гал гарах үед хэрэглэх галын дохиолол сайн дуугарч байгаа эсэхийг шалгалаа. |

Хичээлийн цагаар зовхон төлөвлөгөө гаргах

Үйл ажиллагааг хэрэгжүүлсний дараа үр дүнг бичиж тэмдэглэх

※Хүүхдүүдийн хийсэн бүтээл, ажлын үр дүнг ангид байрлуулсан самбарт тухай бүрд нь нааж байрлуулах.

【Сэтгэгдлээ хуваалцах цаг】

◊step 2 үнэлгээний хуудсыг бөглөх

| Step2 Үнэлгээний хуудас | | | |
|---|---|---|---|
| 배우고 실천하고 나누며 재난에서 살아남기 | Үйл ажиллагааны сэтгэгдэл, үнэлгээ | Огноо | |
| | | Нэр | |

【Хичээлээ эргэн дүгнэх】

| Сонирхолтой гоё байсан зүйл | Хэцүү байсан зүйл | Илүү хийж үзэхийг хүсэж буй зүйл |
|---|---|---|
| | | |

【Анги хамт олны сэтгэгдэл】 Өнөөдөр судалсан агуулгын талаар сэтгэгдлээ чөлөөтэй бичээрэй.

________________________________________

________________________________________

________________________________________

【Сургалтын агуулга】

| Д.д | Агуулга | Үр дүн |
|---|---|---|
| 1 | Өөрийн орон нутгийн эрсдэлийн хүчин зүйлс болон эмзэг байдлыг олж тогтоож чадна | ☆☆☆☆☆ |
| 2 | Өөрийн орон нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах аргыг хэрэгжүүлж чадна | ☆☆☆☆☆ |
| 3 | Гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын төлөвлөгөө гаргаж чадна | ☆☆☆☆☆ |

【Сургалтын агуулга】

| Д.д | Агуулга | Үр дүн |
|---|---|---|
| 1 | Гэр бүлийнхэнтэйгээ болон найзуудтайгаа хамтдаа хийсэн нь даалгаврыг гүйцэтгэхэд тус дэм болсон | ☆☆☆☆☆ |
| 2 | Хичээл дээр төлөвлөсөн агуулгыг шууд хэрэгжүүлэх нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэхэд хэрэг болно. | ☆☆☆☆☆ |

【Сургалтын хэрэглэгдэхүүн】

| Д.д | Агуулга | Үр дүн |
|---|---|---|
| 1 | Манай орон нутгийн аюулгүй байдлын газрын зураг болон гамшгийн эрсдэлийг бууруулах гарын авлага нь гамшгаас урьдчилан сэргийлэхэд тус дэмтэй | ☆☆☆☆☆ |

Step2 Үнэлгээний хуудас

| | | | |
|---|---|---|---|
| 배우고 실천하고 나누며 재난에서 살아남기 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах | Огноо | |
| | | Нэр | |

| | |
|---|---|
| Миний хэрэгжүүлэх зүйлс | |
| Хэзээ | |
| Хэнтэй хамт | |
| Арга | |
| Үр дүн | |

| | | | |
|---|---|---|---|
| Сургалтын сэдэв | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнээс хуваалцах | Хугацаа | 80мин |
| Гол ойлголтууд | Гамшгийн эрсдэлийг бууруулах, хэрэгжүүлэх, хуваалцах | Бэлтгэх зүйлс | Будгийн хэрэгсэл, ватуум цаас |
| Сургалтын зорилго | Сургууль хоорондын хамтын ажиллагаагаар дамжуулан гамшгийн эрсдэлийг бууруулах талаар олон төрлийн мэдээлэл олж авах | | |

★★Энэ сургалтын онцлог

Энэхүү сургалт нь ZOOM ашиглан зохион байгуулах бөгөөд хичээлийн үеэр сургуулиудын ангиуд цахимаар холбогдоно. Бүх үйл явцыг төвөөс удирдаж болох бөгөөд хоёр сургуулийн багш нар ч хамтдаа удирдаж болно.

★★Цагийн төлөвлөлт

| Хугацаа | Агуулга | Үйл ажиллагаа | Бусад |
|---|---|---|---|
| 20мин | Онлайнаар холбогдох бөгөөд интернэтийн нөхцөл байдлыг хянаж шалгах | ZOOM ашиглах | ZOOM ашиглахад ямар нэг асуудал байгаа эсэхийг урьдчилан шалгаж хянах |
| 50мин | Хичээлийн үйл явц | Гамшгийн эрсдэлийг бууруулахад хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ үр дүнг хуваалцах | |
| 10мин | Дүгнэлт | | |

★★Үндсэн агуулга

Манай нутаг болон бусад бүс нутагт ямар эрсдэлт хүчин зүйл байгаа, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ гэдгийг хуваалцах замаар мэдээлэл олж авах, тэгснээр тухайн газар очихдоо урьдчилан бэлдэх боломжтой болохыг онцлох. Бусад бүс нутагт тохиолдож болох гамшиг манай нутагт ч тохиолдож болох тул янз бүрийн гамшгийн эрсдэлт хүчин зүйл, урьдчилан сэргийлэх аргуудыг нэгтгэн дүгнэж, гамшиг тохиолдохоос өмнө сурагчид юу хийж болохыг сурч авцгаая.

【Хөтлөгчийн тайлбар】

◊ Өнөөдрийн сургалт болон үйл ажиллагааны явцыг танилцуулах

- Төслийн танилцуулга (Гамшгийн эрсдэлийг бууруулахын төлөөх сургууль хоорондын хамтын ажиллагаа)
- Сургалтын танилцуулга болон анхаарах зүйлсийг танилцуулах

【Өөрийн сургуулийн танилцуулга болон орон нутгаа танилцуулах】

◊ Сургуулийн танилцуулга

- Сургуулийн талаарх дүрс бичлэг хийж ашиглах
- Сургуулийн эргэн тойрны зураг болон дүрс бичлэгээр ашиглан сургуулийн орчны онцлогийг танилцуулах

【Гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ дүнг хуваалцах】

◊ Өөрийн орон нутгийн эрсдэлийн хүчин зүйлсийг илрүүлж, эрсдэлийг бууруулахын тулд хийсэн ажлынхаа үр дүнг хуваалцах

- Ажлын үр дүнг нэгтгэсэн материал, баримтууд дээр тулгуурлан үр дүнг хуваалцана.

※ Хоёр сургууль ээлжлэн 3 хүн(баг) ажлаа тайлагнах бөгөөд хугацааг баг бүрд 3минут байхаар тогтооно.

- Нөгөө сургуулийнхаа байрладаг бүс нутагт ямар эрсдэлт хүчин зүйлүүд байгаа, эдгээр эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авсан болохыг нэгтгэн цэгцэлж, дүгнэлт хийж сонсох

【Асуулт хариулт】

◊ Танилцуулга хийсэн агуулгаас тодруулахыг хүссэн зүйл байвал харилцан асууж, хариулах

※Танилцуулга хийх дүрс бичлэгийг урьдчилан хийж бэлтгэх

※Танилцуулга хийхдээ хувиараа эсвэл багаараа бэлтгэл хийх. (Танилцуулгаа үр дүнтэй хийхийн тулд урьдчилан материалаа бэлтгэж дасгал сургуулилт хийх хэрэгтэй)

**<Ийм аргыг хэрэгжүүлж болно!>**

① Өмнөх цаг дээр хийсэн урьдчилан сэргийлэх гарын авлагыг үзүүлэн тэдгээрээс нэгийг сонгон хэрэгжилтийн үр дүнг хуваалцах

② Өөрийн бүс нутгийн эрсдэлийн хүчин зүйлийг илрүүлж, хэрхэн урьдчилан сэргийлж байгааг харуулсан дүрс бичлэгээр дамжуулан танилцуулга хийх

③ Эрсдэлийн хүчин зүйлийг илрүүлж, эрсдэлийг бууруулахын тулд авч буй арга хэмжээний зургийг авч, түүнийгээ нэгтгэн танилцуулга (PPT) хийх